

Варикоз буюу “Хөлийн хөх судас” бүдүүрэх эмгэгийн үеийн гал зүү эмчилгээний нөлөөг тодорхойлсон дүн

А.Хонгорболд¹, Б.Гэндэнсүрэн¹, Н.Нямсайхан¹, Г.Ундрах-Ерөөл², Д.Баярцэнгэл², Ч.Батнайрамдал¹, В.Энхтуяа³

¹АШУУИС, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

²АШУУИС, МАУОУС Мэдрэл судлалын резидент

³АШУУИС, МАУОУС, Зүү төөнө заслын танхим

Цахим шуудан: khongorbold@mnum.edu.mn Умас: 99232430

Түлхүүр үг:

Хөлийн вений судасны хэт авиа, хануур, хавхлагын дутмагшил, VAS үнэлгээ

Товч утга:

Үндэслэл: Варикоз буюу хөлийн судас бүдүүрэх үеийн 2-р үе шатанд арьсны гадаргуугаас товойн харагдаж эхэлдэг. Хүндрэх загатнах, өвдөх, үрэвсэх зэрэг шинж тэмдгүүд илэрдэг. Дэлхий дахинд хөлийн судас бүдүүрэх эмгэг нь Хятад, Солонгос, Япон, Монгол, Казакстан улс орнуудад өргөн тохиолддог эмгэг юм. **Арга, аргачлал:** Хөлийн судас бүдүүрэх эмгэгийг оношлоход цусны дэлгэрэнгүй шинжилгээ, цус бүлэгнэлтийн шинжилгээ, тодосгогчтой соронзон резонанс томографи, хөлийн вений судасны хэт авианы шинжилгээнд тулгуурлана. **Үр дүн:** Өвчтөн Б 43 настай эрэгтэй 2 жилийн өмнөөс баруун хөлийн шилбэний судас дагаж халуу төөнөж өвдөнө гэсэн зовууртай, цус бүлэгнэлтийн шинжилгээнд PT, PT INR ихэссэн, хөлийн вений судасны хэт авианы шинжилгээнд Perforant veina 0.45см болж өргөссөн, хавхлагын дутагдалтай. **Дүгнэлт:** Гуяны дотор талаар 0,68см, шилбэний дотор болон гадар талаар 0.46-0.59см өнгөц вений гогцоотой өвчтөнд гал зүү эмчилгээ хийж шинж тэмдэг болон зовуур сайжирсан байна.

Үндэслэл: Варикоз буюу хөлийн хөх судас бүдүүрэх эмгэг нь цусны урсгал саатах, вений судасны хана сулрах, булчингийн шахах хүч сулрах, удамшлын шалтгаанаар судасны хавхлагын дутмагшлаас үүднэ. Варикоз эмгэгийг үүсгэж буй хүчин зүйлд нь жирэмслэлт, таргалалт, гүний вений тромбоз, удаан хугацаанд зогсох нь орно. Монгол улсад 2024 оны нийт өвчлөлийн 13% буюу 469,269 нь зүрх судасны өвчлөл байна үүнээс 2,3%-ийг вений судасны эмгэг эзэлж байна. Варикоз буюу хөлийн судас бүдүүрэх эмгэгтэй 5 хүний тутмын 4 нь эмэгтэй, 1 нь эрэгтэй хүн байна. Монгол улсын нас баралтын тэргүүлэх 5 шалтгааны нэг нь зүрх судасны өвчлөл байна. Хөлийн судас бүдүүрэх эмгэгийн үед өргөссөн судас цавуудах, наах эмчилгээ, өнгөц вений судасны өргөсөл өвчний тариа эмчилгээ, судсан дотуурх мэс заслын эмчилгээг өргөн хэрэглэж байна. Хятад болон Солонгос уламжлалт анагаах ухаанд хөлийн судас бүдүүрэх эмгэгийн үед гал зүү эмчилгээг өргөн хэрэглэж байна. Манай оронд хөлийн судас бүдүүрэх эмгэгийн үед хануур засал эмчилгээг өргөн хэрэглэдэг бөгөөд гал зүү эмчилгээ хийсэн тохиолдол ховор байна.

Эмнэлзүйн тохиолдол: Өвчтөн Б, 43 настай эрэгтэй.

Зовуурь: Баруун хөлийн шилбэний судас дагаж халуу төөнөж өвдөх болсон гэнэ. Их алхах, удаан зогсох үед зовуурь нэмэгддэг.

Өвчний түүх: 2 жилийн өмнөөс дээрх зовуурь эхэлсэн. Олон жил мал малласан, удаан хугацаанд зогсдог, алхдаг.

Үзлэгт: Харж ажиглахад баруун гуяны дотор тал, шилбэний урд болон дотор талаар мэдэгдэхүйц тодорч өргөссөн, тэмтрэлтээр эмзэглэлтэй. Өвдөлтийг 0-10 /VAS/ оноогоор үнэлэхэд 6 байв. (Хүснэгт 1,2)

Хүснэгт 1. Цусны дэлгэрэнгүй шинжилгээ

Үзүүлэлт	Лавлах хэмжээ	Хариу
RBC	4.5-5.5x10 ⁶ /uL	4.6 10 ⁶ /uL
HGB	13-17g/dL	13.3g/dL
HCT	40-50%	39.6%
MCV	83-101fL	86fL
MCHC	31.5-34.5g/dL	33.6g/dL
PLT	150-400x10 ³ /uL	283 10 ³ /uL
WBC	4-11K/uL	8.9K/uL

Хүснэгт 2. Цус бүлэгнэлтийн шинжилгээ

Үзүүлэлт	Лавлах хэмжээ	Хариу
PT	10-12	14.6
PT INR	0.9-1.3	1.34
APTT	25-34	25.9
Fbg C	1.8-3.5 g/L	2.7
TT	14-21	20.8


Хөлийн вений судасны хэт авианы шинжилгээ:

Өнгөц венүүд: Perforant veina 0,45см болж өргөссөн, хавхлагын дутагдалтай. Гуяны дотор талаар 0,68см. Шилбэний дотор болон гадар талаар 0,46-0,59см өнгөц вений гогцоотой.

Эмчилгээ: Үйлчлүүлэгчид 7 хоног цус ялгах зорилгоор гурван үрийн тан 1гр-аар өгөв. 0,6х50 хэмжээтэй ган зүүний үзүүрийг улайсгатал халааж вений судас өргөссөн хэсэгт 2-3 удаа хатгаж 50 мл цус гаргав. Эмчлүүлэгчийн биеийн байдлыг

үнэлэн 7 хоногийн дараа дахин гал зүүгээр хатгалт хийж 55 мл цус гаргав.

Эмчилгээний үр дүн: Эхний удаагийн гал зүү эмчилгээг хийсний дараа шилбэний судас дагаж халуу төөнөж өвдөх зовуурь багассан. Өвдөлтийн 0-10 /VAS/ оноогоор үнэлэхэд 4 байсан. 2 дахь удаагийн гал зүү эмчилгээг хийсний дараа баруун хөлийн зовуурь мэдэгдэхгүй болж, өвдөлтийг 0-10 /VAS/ оноогоор үнэлэхэд 2 болж буурсан байв.



Зураг 1. Доод мөчдийн венийн судасны хэт авианы шинжилгээний харьцуулалт Perforant veina хэсэг-12%, гуяны дотор хэсэг- 12%, Шилбэний дотор болон гадна хэсэг- 14%-аар буурсан.

Хэлцэмж: Phlebology сэтгүүлийн 2023 оны 10 дугаарт Хятадын судлаачдын 260 хүн хамруулсан эмнэлзүйн судалгаа нь myofascial trigger points (MTTrPs) – булчин хальсны гох цэгт зүү эмчилгээ хийх нь доод мөчний вений судасны өргөсөлд эмчилгээний үр дүнтэй гэж үзсэн нь бидний үр дүнтэй дүйж байна.

Journal of Acupuncture research- БНСУ-ын судлаачид СХЭТС-ы үнэлгээ хийгээд 7 хоногт

2 удаа 28 хоног хүртэл хугацаагаар эмчилгээ хийж байсан. Chengshan BL 57, Zu san li ST 36 сүвнүүдийг зонхилон сонгож байна.

Дүгнэлт: Варикоз вен буюу хөлийн судас бүдүүрэх эмгэгийн үед гал зүү эмчилгээ нь шинж тэмдэг болон зовуурийг багасгаж, цусны эргэлтийг сайжруулж, цус зогсонгийг арилгаж, вений судасны өргөслийг бууруулснаар эерэг нөлөө үзүүлж байна.

Ном зүй:

1. Onyou, Jiyeon Lee, Sangmin Park, Jaewook Shin, Saerom Choi, Seongyong Choi Fire Acupuncture for Varicose Veins in the Lower Extremities: A Review of Randomized Controlled Trials, “JAR” 2023;40(3):177-187
2. Lin Liu, Zong-Hui Wu, Qiang-Min Huang, Qing-Guang Liu, Li-Na Wang, Xiao-Hong Jin Clinic observations in treatment of lower extremity varicose veins with trigger points acupuncture Phlebology 2023, Vol. 38(10)675-682
3. Jiang H, Qiu LL, Li YY, Gu LP, Liu QG Zhongguo zhen jiu [Chinese acupuncture & moxibustion], Efficacy and mechanism of fire needling bloodletting for lower extremity varicose veins 2020, 40(9), 953-956
4. Wang L, Chu K, Zeng L, Wang L Zhongguo zhen jiu [Chinese acupuncture & moxibustion], 2016, 36(3), 231-236 | added to CENTRAL: 30 September 2016 | 2016 Issue 9 Primary varicose veins treated with HE's fire needle therapy: a randomized controlled trial
5. Jiang Hua; Clinical observation and quality of life evaluation on treating lower extremity varicose veins by fire-acupuncture bloodletting therapy Clinical Journal of Chinese Medicine. 2020, (34)
6. LIAO Qi;ZHANG Xue-yan;MENG Chibo;ZHANG Tao;YANG Ting;XIE Anshu;AN Ya-bin;Linjiang Branch of the Second People's Hospital of Neijiang; Clinical Efficacy of Qing Long Bai Wei Acupuncture Method Combined with Fire Needle Bloodletting for Lower-extremity Varicose Veins and Its Effect on Hemorheology Shanghai Journal of Acupuncture and Moxibustion. 2021, (12)
7. Clinical Effect of Bloodletting Therapy on Primary Superficial Varicose Veins of Lower Limbs Based on Lower Limb Vein Color Ultrasound 2021,(06) DOI:10.27021/d.cnki.gfjzc.2023.000197
8. Research Progress of Bloodletting Therapy in the Treatment of Primary Lower Extremity Varicose Veins 2021, (06)

The Effect of Fire Acupuncture Treatment in Varicose Veins Lower Extremities

Khongorbold A¹, Gendensuren B¹, Nyamsaikhan N¹, Undrakh-Yeruul G², Bayartsengel D², Batnairamdal Ch¹, Enkhtuya V²

¹ Department of Traditional Medicine, International School of Mongolian Medicine, MNUMS

² International School of Mongolian Medicine, MNUMS

E-mail: khongorbold@mnums.edu.mn Tel:+976- 99232430

Keywords:

Lower limb venous Doppler, valve insufficiency, Bloodletting, VAS assessment

Background: Varicose veins, or chronic venous insufficiency, become visibly noticeable from the second stage when veins start appearing on the surface of the skin. Symptoms include severe itching, pain, swelling, and inflammation. Chronic venous insufficiency is a common condition in countries such as China, South Korea, Japan, Mongolia, and Kazakhstan. Diagnosis of varicose veins relies on blood flow studies, coagulation tests, contrast-enhanced magnetic resonance imaging (MRI), and Doppler ultrasound of the venous system. Patient B, a 43-year-old male, has experienced pain and swelling in the right lower limb vein for the past two years, especially when exposed to heat. Coagulation tests show PT and PT INR within normal range. Doppler ultrasound of the venous system revealed that the perforating vein is dilated to 0.45 cm and has valve insufficiency. In the deep veins, a width of 0.68 cm was measured, while superficial veins ranged between 0.46–0.59 cm. After receiving appropriate treatment from the Department of Fire Acupuncture, the patient's symptoms have improved.